



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/594

Хэрлэн сум


Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн
спортын арга дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн өдрийн тохиолдуулан зохион байгуулж буй хэмжээ болон хэлэлцүүлэх зохион байгуулах зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шагнал урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ